



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2016 оны 2 дугаар сар

Гадаад худалдааны эргэлт: \$965.4 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 965.4 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 20.6%-иар буюу 250.2 сая ам.доллараар буурсан. Үүнд экспорт 139.9 сая ам.доллараар, импорт 110.2 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 62.3% буюу 601.9 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 10.8% буюу 104.7 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 18.2%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 34.0%-иар тус тус буурчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: \$261.2 сая

Мөнгөн дүн 2016 оны эхний 2 сарын байдлаар гадаад худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 29.7 сая ам.доллараар буурснаар 261.2 сая ам.долларын ашигтай гарлаа. Энэ нь импорт 110.2 сая ам.доллараар буурсан ч экспорт түүнээс өндөр дүнгээр буюу 139.9 сая ам.доллараар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын гулсах дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан боловч 2014 оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсан тул жилийн өсөлтийн зөрүү өссөн. Харин 2015 он гарсаар зэсийн баяжмалын экспортын нөлөө тогтворжиж, өсөлтийн зөрүү буурч байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: \$243.8 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлт юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны сүүлийн хагасаас эхлэн тогтмол ашигтай гарч байна. 2016 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 243.8 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 56.2 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна. Үүнд валютын төлбөртэй экспорт 21.7%-иар буурсан нь нөлөөлсөн.

Гадаад худалдааны нөхцөл: 1.229 (Туршилт тооцоо)


2016 оны 2 дугаар сарын байдлаар гадаад худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс 22.1%-иар буурч, өмнөх сараас 7.8%-иар өсч 1.229-д хүрлээ.

Гадаад худалдааны нөхцөл ийнхүү өөрчлөгдөхөд импортын үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8%-иар өссөн, экспортын үнийн индекс 20.7%-иар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Экспортын үнийн бууралтанд зэсийн баяжмал, чулуун нүүрс, төмрийн хүдэр, түүхий нефтийн хилийн дундаж үнэ буурсан нь голлон нөлөөлсөн бол импортын үнэд нефтийн бүтээгдэхүүний үнэ буурсан, хөрөнгө оруулалтын барааны үнэ өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 2 сар			Өөрчлөлт			
	2016	2015	2014	2016/2015		2015/2014	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	965.4	1215.6	1208.5	-250.2	-20.6%	7.1	0.6%
Экспорт	613.3	753.2	594.6	-139.9	-18.6%	158.6	26.7%
Импорт	352.1	462.4	613.9	-110.2	-23.8%	-151.5	-24.7%
Тэнцэл	261.2	290.9	-19.3	-29.7	-10.2%	310.2	

Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын гулсах дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар/



Бүтэц: 85% + 15%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4%-иар буурч нийт экспортын 85%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 84%, нийт экспортын 71%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4 нэгж хувиар буурсан бол нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны түвшинд хадгалагдсан байна.

Өсөлт: -18.6%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 18.6%-иар буурсан бөгөөд үүнд ашигт малтмалын экспортын бууралт голлон нөлөөлжээ. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефть, мөнгөжөөгүй алтны экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 33%, 8%, 66%, 25%, 35%-иар буурсан нь ашигт малтмалын экспортыг 20%-иар бууруулжээ.

Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүн тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 74.8 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 214.8 сая ам.доллараар буурснаар нийт дүнгээр 139.9 сая ам.доллараар буурсан байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмал, боловсруулаагүй нефтийн тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж экспорт 130 сая ам.доллараар өссөн бол мөнгөжөөгүй алт, чулуун нүүрс, төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ буурсан, мөн ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ буурснаас шалтгаалж экспорт 271 сая ам.доллараар буурсан байна.

Ямааны самнасан ноолуурын тоо хэмжээ болон үнэ буурснаар уг бүлгийн экспорт 2.8 сая ам.доллараар буурсан. Харин бусад экспортын бүтээгдэхүүний хувьд үнэ болон тоо хэмжээ өссөнөөр өмнөх оны мөн үеэс 8.2 сая ам.доллараар өссөн байна.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны үнэ 2016 оны 2 дугаар сарын 29-ний байдлаар 1,239 ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2.1%-иар, өмнөх сараас 10.8%-иар өссөн байна.


А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ 2016 оны 2 дугаар сарын 29-ний байдлаар харгалзан 4,706, 49 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэс 3.0%-иар төмрийн хүдэр 14.0%-иар тус тус өссөн байна. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад зэс 20.6%-иар, төмрийн хүдэр 23.4%-иар тус тус буурчээ.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2016			2015			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мян.тн, мян.бар, кг)	Дүн	%	Тоо/хэм (мян.тн, мян.бар, кг)	Дүн	%	Дүн	Өсөлт	% 2
1. Ашигт малтмал	523	85%		668	89%		(145)	↓-22%	-19.3%
Чулуун нүүрс	1 431	44	7%	1 711	66	9%	(22)	↓-33%	-3%
Зэсийн баяжмал	274	334	54%	206	363	48%	(29)	↓-8%	-4%
Төмрийн хүдэр/баяж.	575	16	3%	790	47	6%	(31)	↓-68%	-5%
Боловсруулаагүй нефть	1 429	44	7%	1 219	59	8%	(15)	↓-25%	-2%
Цайрын хүдэр ба баяж.	11	10	2%	17	22	3%	(12)	↓-56%	-2%
Мөнгөжөөгүй алт	1 697	64	10%	2 456	98	13%	(34)	↓-35%	-5%
Жонш лейцит, нефелинт	33	8	1%	32	8	1%	0	↑1%	0%
Молибдений хүдэр/баяж	1	4	1%	1	6	1%	(1)	↓-24%	0%
2. Ноос, ноолуур	2.2	0%		5.0	1%		(3)	↓-56%	-0.4%
Ямааны угаа ноолуур	-	-	0%	-	-	0%	-	-	0%
Ямааны сам ноолуур	31	2	0%	51	5	1%	(2.8)	↓-56%	0%
3. Бусад	88	14%		80	11%		8	↑10%	1.1%
Нийт дүн	613			763			(139.9)	↓-18.6%	

% - Булгийн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)
% 2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)


Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Ашигт малтмал	72		(217)		(145)	
Чулуун нүүрс	(11)	-49%	(11)	-51%	(22)	-33%
Зэсийн баяжмал	120	409%	(149)	-509%	(29)	-8%
Төмрийн хүдэр ба баяжмал	(13)	-41%	(19)	-59%	(31)	-66%
Боловсруулаагүй нефть	10	68%	(25)	-168%	(15)	-25%
Цайрын хүдэр ба баяжмал	(8)	-68%	(4)	-32%	(12)	-56%
Мөнгөжөөгүй алт	(30)	-88%	(4)	-12%	(34)	-35%
Жонш лейцит, нефелинт	0	301%	(0)	201%	0	1%
Молибдений хүдэр ба баяжмал	4	292%	(5)	-392%	(1)	-24%
2. Ноос, ноолуур	(1.9)		(0.9)		(2.8)	
Ямааны угаасан ноолуур	-	-	-	-	-	-
Ямааны самнасан ноолуур	(1.9)	-69%	(0.9)	-31%	(2.8)	-56%
3. Бусад	5	56%	4	44%	8.2	10%
Нийт	74.8		(214.8)		(139.9)	

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнийн динамик



Бүтэц: 36% + 30% +18% +15%

Оны эхний 2 сарын байдлаар нийт импортын 36%-ийг хэрэглээний бүтээгдэхүүн, 30%-ийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 15%-ийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгж хувиар, хэрэглээний бүтээгдэхүүн 2 нэгж хувиар тус тус өссөн байна.

Өсөлт: -23.8%

Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 5%-ийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 6%-ийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 11%-ийг тус тус тайлбарлаж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 19%-иар буюу 24 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 19%-иар буюу 29 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 48%-иар буюу 51 сая ам.доллараар буурсан нь нийт импортийг 23.8%-иар буюу 110 сая ам.доллараар буурахад голлон нөлөөлжээ.

Задаргаа

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оны мөн үеэс 19%-иар буюу 29 сая ам.доллараар буурахад түргэн эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 19%-иар буюу 17 сая ам.доллараар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 19%-иар буюу 12 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ. Түргэн эдэлгээтэй бүтээгдэхүүний импорт буурахад хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа сахар, кокоа, шоколад болон сүү, сүүн бүтээгдэхүүний импортын бууралт голлон нөлөөлсөн. Хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт 2014 оны 6-р сараас эхлэн тогтмол буурч тайлант хугацааны эцэст сөрөг тэмдэгтэй 20%-д хүрсэн /Дүрслэл 7/.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурахад машин, механизм, тоног төхөөрөмж, түүний эд анги 24%-иар буюу 19 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Түүнчлэн барилгын материалын импорт 28%-иар буюу 9 сая ам.доллараар буурсан байна.

Аж үйлдвэрлэлийн орцын импорт 7%-иар буюу 5 сая ам.доллараар буурсан. Уг бууралтыг цахилгаан эрчим хүчний импортын бууралт голлон тайлбарлаж байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт 48%-иар буюу 51 сая ам.доллараар буурсан. Нефтийн импортын бууралтад хилийн үнээс гадна импортын тоо хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 32%-иар буурсан нь нөлөөлсөн байна.


Нефтийн бүтээгдэхүүний хилийн үнэ 2013 оны төгсгөлөөс эхлэн тогтмол буурсан ба 2015 оны 2-р сард 2010 оноос хойшхи хамгийн доод түвшиндээ хүрсэн. Харин 2015 оны 3-р сараас эхлэн эргэн өссөн боловч 8-р сараас буурч 2016 оны 2 сарын байдлаар тонн тутамд 466.3 ам.долларт хүрээд байна.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)


Төрөл	2016		2015		Өөрчлөлт		
	Дүн	%	Дүн	%	Дүн	Өсөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	128.2	36%	157.6	34%	(29.4)	-19%	-6%
Түргэн эдэлгээтэй	73.8	21%	90.7	20%	(16.9)	-19%	-4%
Хүнс	50.4	14%	63.1	14%	(12.7)	-20%	-3%
Эм, тариа	9.2	3%	9.7	2%	(0.4)	-4%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	14.2	4%	18.0	4%	(3.8)	-21%	-1%
Удаан эдэлгээтэй	54.4	15%	66.9	14%	(12.5)	-19%	-3%
Гутал, хувцас, цунх	5.6	2%	6.5	1%	(0.9)	-13%	0%
Гэр ахуйн цах. хэрэгсэл ба төвөг	11.7	3%	18.2	4%	(6.5)	-36%	-1%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	29.0	8%	34.6	7%	(5.6)	-16%	-4%
Бусад удаан эдэлгээтэй бараа	8.1	2%	7.6	2%	0.5	7%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	103.9	30%	128.4	28%	(24.5)	-19%	-5%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	60.4	17%	79.5	17%	(19.1)	-24%	-4%
Суулаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	11.0	3%	11.3	2%	(0.3)	-3%	0%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	49.4	14%	68.2	15%	(18.8)	-28%	-4%
Барилгын материал	22.8	6%	31.8	7%	(9.0)	-28%	-2%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	20.8	6%	17.1	4%	3.7	22%	3%
Аж үйлдвэрлэлийн орц	65.0	18%	69.7	15%	(4.7)	-7%	-1%
Хүнсний орц	11.5	3%	5.5	1%	6.0	109%	1%
Химийн бүтээгдэхүүн	9.2	3%	8.5	2%	0.6	7%	1%
Даавуу, утас, арьс, савхин эдгэл	1.7	0%	2.1	0%	(0.4)	-18%	0%
Цахилгаан эрчим хүч	12.6	4%	20.5	4%	(7.8)	-38%	-2%
Мэт алсын хүүдэр, баяжмал болон хялгдал	0.4	0%	0.0	0%	0.4	x10	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	29.6	8%	33.1	7%	(3.5)	-11%	-1%
Нефтийн бүтээгдэхүүн	54.5	15%	105.6	23%	(51.1)	-48%	-11%
Дизель түнш	23.5	7%	51.5	11%	(28.0)	-54%	-6%
АИ-92, АИ-95	21.2	6%	40.3	9%	(19.2)	-48%	-4%
А-80 болон бусад	9.9	3%	13.8	3%	(3.9)	-28%	-1%
Бусад	0.5	0%	1.2	0%	(0.7)	-30%	0%
Нийт дүн	352.1		462.4		(110.2)	-23.8%	

% - Бүтцийн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)
% 2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нийт импортын задаргаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 8. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ

